



Гар ариутгагчинд гал авалцсанаас үүдсэн түлэгдэлт

Ажилтан КОВИД-19-н эсрэг авах арга хэмжээг баримталж гараа спирттэй гар ариутгагчаар ариутгаж хэрэглэдэг.

Улмаар ажилтан гар ариутгагч түрхээд хатаж амжаагүй байхад нь статик хуримтлагдаж гал асаах эх үүсвэр болсон металлд хүрсэн.

Гар ариутгагчид гал авалцаж, хоёр гар нь нүдэнд харагдах төдий дөлөөр бүрхэгдсэн. Ажилтан дөлийг унтраасан боловч 1 болон 2-р зэргийн түлэгдэлтэнд өртсөн.

Эх сурвалж: International Association of Oil & Gas Producers (IOGP) Alert 314 IOGP Safety. (<https://safetyzone.iogp.org/>).

Үүнтэй ижил гар ариутгагч хэрэглэсний дараа тамхи асааж байгаад гарт нь гал авалцсан тохиолдлууд ч гарсан байсан.

Та үүнийг мэдэх үү?

- Зарим төрлийн гар ариутгагч нь спиртэн суурьтай байдаг бөгөөд тэдгээрийн шаталтын хамгийн бага температур нь 16.6 - 26.7°C хэм байдаг. Температур нь шаталтын түвшнээс хэтэрсэн тохиолдолд оч үсрэх төдийд гал гарахад бэлэн болсон байдаг.
- Ихэнх гар ариутгагч шаталтын түвшин, түүний аюул болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний жагсаалт бүхий Safety Data Sheet (SDS) буюу Аюулгүйн мэдээллийн хуудастай байдаг.
- Спирттэй гар ариутгагч түрхсэн чийгтэй гараар статик оч эсвэл аливаа бусад төрлийн гал гаргах эх үүсвэрт хүрэлцвэл гал авалцаж болзошгүй. Хүмүүс гал авалцах хангалттай хэмжээний статик цэнэгтэй байдаг.
- Спиртэнд авалцсан гал нүдэнд харагдахгүй шахам маш бүдэг хөх туяатай байна. Спиртэнд авалцсан жижиг галыг усаар унтрааж болно.
- Зарим гар ариутгагч шатамхай, хортой бодис болох метанол эсвэл метилийн спирт агуулсан байдаг.

Ийм төрлийн бодисыг арьсандаа бүү хүргэ!

1. <https://www.fda.gov/drugs/drug-safety-and-availability/fda-updates-hand-sanitizers-methanol>

Та юу хийж чадах вэ?

- Спирт агуулсан чийгшүүлэгч эсвэл гар ариутгагч ашигласны дараа гал авалцуулж болзошгүй аливаа ажлыг хийхээс өмнө гараа бүрэн хатааж байх.
- Хэдий аюулгүй гэж бодож байсан ч өөрийн хэрэглэж буй бүх төрлийн бодисын Аюулгүйн мэдээллийн хуудастай танилцаж байх.
- Спирт суурьтай гар ариутгагчийг хадгалахдаа Аюулгүйн мэдээллийн хуудасны дагуу хадгалах ба гал авалцах чанарыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний үр нөлөөг нь бууруулдаг тул нарны гэрэл болон халуун ялгаруулагч эх үүсвэрээс хол байрлуулна.
- Энэхүү мэдээллийг гэр бүл, найз нөхдөдөө дамжуулж ижил төрлийн осолд өртөхөөс сэргийлээрэй.

Handle all materials safely, even those meant to keep you safe!!

Бүх төрлийн материалыг, тэр байтугай таныг хамгаалах зориулалттай материалыг ч болгоомжтой ашигла!